



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 05 өдөр

Дугаар А/446

Хэрлэн сум

Эрт илрүүлэг, үзлэгийн үйл  
ажиллагаанд дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Нэгдсэн эмнэлэгт хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ, оношилгоог зохион байгуулахад иргэд болон анхан шатны эмч нарт мэдээлэл хүргэх зардалд 8,200,000 (найман сая хоёр зуун мянга) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн тухайн төсвийн жилийн явцад шинээр батлагдсан хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэхэд шаардагдах нэмэлт зардлаас олгохыг Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2022  
оны ... дугаар сарын ...-ны  
... захирамжийн хавсралт

Зардлын задаргаа

№	Зардлын төрөл	Нэг бүрийн үнэ	Тоо ширхэг	Нийт үнэ
1.	Масс мессеж	300	10,000	3,000,000
2.	Сурталчилгааны материал	1,000	2,000	2,000,000
3	Эмнэлгийн 1, 4 дүгээр давхарт дуугүй хөтөч хийх	320,000	10	3,200,000
4.	Нийт			8,200,000